



ДЭД БҮТЦИЙН САЛБАРТ ТӨР ХУВИЙН ХЭВШЛИЙН ТҮНШЛЭЛИЙГ (PPP) ХЭРЭГЖҮҮЛЭХ НЬ:

Хураангуй:

Дэд бүтэц тэр дундаа уул уурхай дагасан дэд бүтцийг хөгжүүлэх хэрэгцээ шаардлагыг тодорхойлж, бусад орнуудад дэд бүтцийн томоохон төслүүдийг төр хувийн хэвшлийн хамтын ажиллагаагаар хэрэгжүүлдэг арга хэлбэрүүд, тэдгээрийн хэрэглээ, түүнийг манай улсад нэвтрүүлэх зорилгоор хийсэн судалгааны үр дүнг толилуулж байна.

Abstract:

This aims to define critical need for development of infrastructure project and to determine models which are large scale infrastructure projects are implemented through Public-Private-Partnership in developing countries, its practice. I have submitted result of paper which is appropriate models for Mongolian infrastructure sector.

Түлхүүр үг:

Дэд бүтцийн салбар, төр хувийн хэвшлийн түншлэл (Public-Private-Partnership), барих-ашиглах-шилжүүлэх (Build-Operate-Transfer), барих-өмчлөх-ашиглах (Build-Own-Operate)

Оршил:

Аливаа улс орны тогтвортой хөгжлийн тулгуур нөхцлүүдийн нэг нь дэд бүтцийн салбарын хөгжил байдаг тул засгийн газрын бодлого, зохицуулалт нь энэ салбарыг тогтвортой хөгжүүлэхэд чиглэгддэг. Ялангуяа уул уурхайн салбар нь дэд бүтцийн хөгжлөөс ихээхэн хамааралтай байдаг бөгөөд хөгжиж

Н.Дамдиндорж

буй орнуудын уул уурхайн бүтээгдэхүүний өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх, дэлхийн зах зээл дээр гаргахад дэд бүтэц чухал үүрэгтэй. Дэд бүтцийн салбарт эрчим хүч, тээвэр, харилцаа холбоо, нийгмийн дэд бүтэц /боловсрол, эрүүл мэнд/ хамаарна.

Олон улсын туршлагаас харахад дэд бүтцийн төслүүдийг төсвийн хөрөнгөөс гадна хувийн хөрөнгө оруулалтаар санхүүжүүлдэг жишиг байна. Манай улсын хувьд ч 2009 онд Засгийн газраас “Төр хувийн хэвшлийн түншлэлийн талаар төрөөс баримтлах бодлого”-ыг баталж “Дэд бүтцийн болон нийгмийн суурь үйлчилгээг нийтэд үзүүлэх, Засгийн газраас тэргүүлэх ач холбогдол өгч байгаа, төсөл хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд төр, хувийн хэвшил хамтран ажиллах, төрийн тодорхой чиг үүргийг хувийн хэвшилээр гүйцэтгүүлэх замаар эдгээр салбар дахь төрийн оролцоог оновчтой болгох, суурь үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах, төсвийн үр ашгийг дээшлүүлэхэд чиглэнэ” гэж заажээ. 1990-ээд оны эхэн үес дэлхий нийтээр, түүний дотор хөгжиж буй орнуудад дэд бүтцийн салбарын төслүүдийг төр, хувийн хэвшил хамтран хэрэгжүүлэх болсон бөгөөд энэхүү судалгаа нь энэ практикийг Монгол улсад нэвтрүүлэх асуудалд чиглэсэн.


Нэг. Уул уурхайн салбарын хөгжил, тулгамдсан асуудлууд

Сүүлийн 6 жилийн турш манай улсын уул уурхай, олборлолтын салбар дотоодын нийт бүтээгдэхүүн (ДНБ)-ий 20 орчим хувийг, аж үйлдвэрийн нийт бүтээгдэхүүний 70 орчим

Дэд бүтцийн салбарт төр хувийн хэвшлийн түнлэлийг (PPP) хэрэгжүүлэх нь

хувийг, экспортын бүтээгдэхүүний 90 орчим хувийг тогтмол эзэлж байгаагаас (дүрслэл 1) үзэхэд энэ салбар Монгол улсын эдийн засгийн гол хөдөлгөх хүч болсон бөгөөд төр засаг болон гадаад, дотоодын хөрөнгө оруулагчдын анхаарлын төвд байгааг харуулж байна.


Дүрслэл 1. Уул уурхай, олборлолтын салбарын эдийн засагт эзлэх хувийн жин



Эх сурвалж: Үндэсний статистикийн газрын мэдээ. www.1212.mn

Иймд дан ганц уул уурхайд түшиглэсэн эдийн засгийн хөгжлийн бодлогын эерэг болон сөрөг талуудыг харгалзан, уул уурхайгаас орсон орлогоор нийгэм, эдийн засгийн бусад салбаруудыг хөгжүүлэхийн тулд уул уурхайн бүтээгдэхүүний өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх, түүний дотор уул уурхай дагасан дэд бүтцийн хөрөнгө оруулалтыг оновчтой шийдвэрлэх шаардлагатай. Олон улсын аудитын "Ernst and Young Global" компаниас уул уурхайн компаниудын дунд жил бүр хийдэг судалгаанаас үзэхэд сүүлийн 6 жилийн хугацаанд уул уурхайн салбарын топ 10 эрсдэлийн нэгээр дэд бүтцийн салбараас үүдэлтэй эрсдлүүд тогтмол орсоор байгаа нь¹ (дүрслэл 2) уул уурхай, олборлолтын салбар нь дэд бүтцийн салбарын хөгжлөөс шууд хамааралтайг харуулж байна.

Дүрслэл 2. Хөгжиж буй орнуудын уул уурхайн салбарт дэд бүтцийн салбараас үүдэлтэй эрсдэл



Эх сурвалж: "Ernst and Young Global"

Мөн судлаачид Монгол улсын уул уурхайн салбарын өсөлтийн тогтвортой байдал, эдийн засгийн үр ашиг, өрсөлдөх чадварт дэд бүтцийн салбарын хөгжил чухал нөлөөтэй² гэж үзжээ. Сүүлийн 5 жилд дэд бүтцийн салбараас үүдэлтэй эрсдэл хөгжиж буй орнуудын уул уурхайн салбарт илүү

1 Ernst and Young Global. "Business risks facing mining and metals". 2009-2014

2 EURASIA CAPITAL "Infrastructure in Mongolia: Challenges and Opportunities". 2009

Дэд бүтцийн салбарт төр хувийн хэвшлийн түнлэлийг (PPP) хэрэгжүүлэх нь

тулгамдаж буй асуудал байсан боловч 2013-2014 онуудад энэхүү зэрэглэл буурсан нь харагдаж байна. Харин манай орны хувьд энэ жилүүдэд дэд бүтцийн салбарт их хэмжээний хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалт хийж чадаагүй учраас энэ эрсдлийн зэрэглэл буурагуй гэж үзэж байна.

Хоёр. Манай улсын дэд бүтцийн салбарт шаардагдах хөрөнгө оруулалтын хэмжээ ба улсын төсөв

Хүснэгт 1. Ази, Номхон далайн улс орнуудын дэд бүтцийн салбарт 2010-2020 д шаардагдах хөрөнгө оруулалт

№	Улсын нэр	Дүн /тэрбум ам.дол/	Нийт ХО-ын дүнд эзлэх хувийн жин	Дүн /тэрбум төгрөг/ 1 ам.доллар = 1900 төгрөг
1	Хятад	4,367.6	53,1%	8,298,440.0
2	Энэтхэг	2,172.5	26,4%	4,127,750.0
3	Малайз	188.0	2,3%	357,200.0
4	Тайланд	172.9	2,1%	328,510.0
5	Монгол	10.1	0,12%	19,190.0
6	Бусад /27 улс/	1,311.4	15,98%	2,491,660.0
	Дүн	8,222.5	100%	15,622,750.0

Эх сурвалж: "ADB" working paper series, No. 248, Estimating demand for infrastructure in energy, transport, telecommunication, water and sanitation in Asia and the Pacific:2010-2020

Өнөөдөр манай улсад гадаадын хөрөнгө оруулалт буурсан, дотоодын эх үүсвэр хүрэлцэхгүй байгаагаас санхүү-эдийн засгийн хүндрэл бий болж, түүнийг даван туулах нь өнөөгийн болон ирээдүйн тулгамдсан асуудал болон хэлэлцэгдэж байгаа билээ. Сүүлийн 6 жилийн статистик мэдээллээс харахад жилд дунджаар 420.0 гаруй тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтыг дэд бүтцийн салбарт оруулсан боловч ирэх 10 жилийн хугацаанд дэд бүтцийн салбарт ойролцоогоор 19.2 их наяд төгрөгийн санхүүжилт шаардлагатай байгаа³ юм. Эндээс үзэхэд ирэх 10 жилийн


Дэд бүтцийн салбар нь улс орны эдийн засагт үзүүлэх шууд ба дам нөлөө, гүйцэтгэх үүрэг, анхны хөрөнгө оруулалтын хэмжээ, зардлаа эргүүлэн нөхөн төлөх хугацаа зэрэг олон үзүүлэлтийн хувьд онцлогтой. Дэд бүтцийн төслүүд нь өндөр өртөгтэй, урт удаан хугацаанд ашиглагдах хөрөнгийн бүтээн байгуулалт байдаг учраас төслүүдийг хэрэгжүүлэхэд аливаа улс орны засгийн газрын өмнө тулгардаг нэг том асуудал бол санхүүжилтийн эх үүсвэр юм.

хугацаанд дэд бүтцийн салбарт жил бүр 1.5 их наяд төгрөгийн нэмэлт санхүүжилт шаардагдах болно.

Хуримтлуулсан сан нөөц байхгүй, үрсгал зардлаа нөхөх төдий байгаа манай улсын төсвийн хувьд энэ их зардлыг хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтаар түүний дотор гадны хөрөнгө оруулагчдийн эх үүсвэрээр санхүүжүүлэхээс өөр аргагүй. Дэд бүтцийн салбарт шаардагдаж байгаа энэхүү нэмэлт санхүүжилт нь манай орны сүүлийн 6 жилийн дундаж ДНБ-ий 10,7 хувь, нийт төсвийн орлогын 33,8 хувь, дотоодын нийт хөрөнгө оруулалтын 62,2 хувийг эзлэх (дүрслэл 3) их хэмжээний дүн юм.

³ Asian Development Bank Institute (ADB) working paper series, No. 248, Estimating demand for infrastructure in energy, transport, telecommunication, water and sanitation in Asia and the Pacific: 2010-2020

Дүрслэл 3. Шаардлагатай нэмэлт санхүүжилтийн хэмжээний үзүүлэлтүүдэд эзлэх хувийн жин



Эх сурвалж: Үндэсний статистикийн газрын мэдээ. www.1212.mn

Иймд дэд бүтцийн хөгжилд хувийн хэвшлийн хөрөнгө оруулалт шаардлагатай бөгөөд дэд бүтцийн том төслүүдийг төр болон хувийн хэвшил хамтран, эсвэл хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтаар санхүүжүүлэн гүйцэтгэдэг туршлагад тулгуурлах нь зайлшгүй хэрэгцээ болоод байна.

Гурав. Төр хувийн хэвшлийн түншлэл (Public-Private-Partnership)


1990-ээд оны эхэн үеэс дэлхий нийтэд дэд бүтцийн салбарт хэрэгжүүлэх төслийг санхүүжүүлэх шилдэг туршлага гарч ирсэн нь Public-Private-Partnership (ЗР гэж нэрлэдэг) буюу төр хувийн хэвшлийн түншлэл (ТХХТ) юм. Түншлэлийн энэхүү хэлбэрийн үед төрөөс хувийн хэвшилтэй хамтарсан компани байгуулж эсвэл хувийн өмчийн компаниуд дангаар тодорхой хугацаанд концессийн зүйлийг гэрээний үндсэн дээр эзэмшиж, хэрэгжүүлэх ба хугацааны эцэст төрд эргүүлэн өгөх нөхцөлтэй байдаг. Хувийн өмчийн компаниуд концессийн гэрээний хугацаанд тухайн зүйлтэй холбоотой бүх эрсдлийг хариуцаж, өгөөжийг хүртдэг. Дэд бүтцийн төслийг хэрэгжүүлэх энэ загварт төрөөс гадна олон тооны хувийн өмчийн эдийн засгийн субьектүүд (хөрөнгө оруулагч, зээлдүүлэгч, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагч зэрэг) татагдан оролцсоноороо (дүрслэл 4) эдгээр субьектүүд бусад салбаруудыг ч идэвхжүүлэх нөлөө үзүүлдэг.



Эх сурвалж: N. Damdindorj. "Research on Theoretical Basis of Project Finance and Its Implementation in Mongolian Mining Project", 2012

Дэд бүтцийн салбарт төр хувийн хэвшлийн түншлэлийг (PPP) хэрэгжүүлэх нь

Төр хувийн хэвшилтэй хамтран төсөл хэрэгжүүлэхдээ одоо байгаа хуучин зүйлийг шилжүүлэх, шинэ зүйлийг хувийн хэвшил дангаараа эсвэл хамтарсан субъект барьж байгуулах, төрийн эсвэл хувийн хэвшлийн эрх мэдэл давамгайлах байдал зэргээс хамааруулан хэрэгжүүлэх олон хувилбар ашигладагийг дүрслэл 5-д нэгтгэн үзүүлэв.



Эх сурвалж: PPIAF “PPP Basics and Principles of a PPP Framework”, 2012

Дэлхийн банкны тооцоогоор 1990-2014 онуудад дэлхий улс орнуудад нийт 2 их наяд 413 тэрбум ам.долларын хөрөнгөөр 6,400 гаруй төсөл төр хувийн хэвшлийн түншлэлийн хэлбэрээр хэрэгжсэн бөгөөд тэдгээрийн 3,000 орчим нь буюу 48 хувь нь эрчим хүчний салбарт, 1,600 орчим нь буюу 25 хувь нь тээврийн салбарт, үлдсэн 1,800 орчим төсөл харилцаа, холбоо болон нийгмийн дэд бүтцийн салбарт (дүрслэл 6) хэрэгжжээ.

Дүрслэл 6. Төр хувийн хэвшлийн түншлэлийн салбарууд



Эх сурвалж: Дэлхийн банк. www.worldbank.org

Төр хувийн хэвшлийн түншлэлд Барих-Ашиглах-Шилжүүлэх (ВОТ), Барих-Өмчлөх-Ашиглах (ВОО), Барих-Шинэчлэн сайжруулах-Ашиглах-Шилжүүлэх (BROT), Шинэчлэн сайжруулах-Ашиглах-Шилжүүлэх (ROT) гэсэн түгээмэл хэрэглэгддэг хэлбэрүүд байдаг бөгөөд Дэлхийн банкны судалгаанд хамрагдсан 6,400 гаруй төслөөс 1,812 (28%) төсөл нь Барих-Ашиглах-Шилжүүлэх (ВОТ), 1,295

Дэд бүтцийн салбарт төр хувийн хэвшлийн түншлэлийг (PPP) хэрэгжүүлэх нь

(20%) Барих-Өмчлөх-Ашиглах (BOO) хэлбэрээр хэрэгжсэн байгаагаас (дүрслэл 7) үзвэл нийт төслийн 50 орчим хувьд нь эдгээр хэлбэр зонхилж байна.

Дүрслэл 7. Төр хувийн хэвшлийн түншлэлийн хэлбэр



Эх сурвалж: “Дэлхийн банк”. www.worldbank.org

Манай улсын дэд бүтцийн салбарт жил бүр шаардагдах 1.5 орчим их наяд төгрөг буюу 790 сая орчим ам.долларын санхүүжилт нь Дэлхийн нийт болон Зүүн ази, Номхон далайн орнуудад (хүснэгт2) сүүлийн 6 жилийн хугацаанд хэрэгжүүлсэн төслүүдийн санхүүжилтийн дундаж эх үүсвэрийн 4,4 ба 0,4 хувийг тус тус эзэлж байгаагаас үзвэл бид гадны хөрөнгө оруулалтын орчиноо сайжруулж, итгэлийг нь олж чадвал хангалттай боломж байгааг илтгэж байна.

Хүснэгт 2. 2009-2014 оны Дэлхий нийт болон Ази, Номхон далайн хөгжиж буй орнуудад хэрэгжсэн дэд бүтцийн төслийн мэдээ

№	Үзүүлэлт	2009	2010	2011	2012	2013	2014	Дундаж
1	Төслийн тоо - Дэлхий нийтэд	287	307	427	409	291	325	341
2	Нийт хөрөнгө оруулалт - Дэлхий нийтэд /сая ам.доллар/	157,234	187,862	176,452	195,202	150,353	213,596	180,116
3	Төслийн тоо-Зүүн Ази, Номхон далайн орнууд	78	62	116	85	85	67	82
4	Нийт хөрөнгө оруулалт - Зүүн ази, Номхон далайн орнууд /сая ам.доллар/	18,175	18,503	15,505	17,876	19,420	18.924	18,067

Эх сурвалж: Дэлхийн банк. www.worldbank.org

Хүснэгт 3-аас үзэхэд эрчим хүчний салбарт хэрэгжсэн нийт төслийн 39 хувь нь Барих-Өмчлөх-Ашиглах (BOO), 30 хувь нь Барих-Ашиглах-Шилжүүлэх (BOT) хэлбэрээр, тээвэрлэлтийн салбарт 37 хувь нь Барих-Шинэчлэн сайжруулах-Ашиглах-Шилжүүлэх (BROT), 30 хувь нь Барих-Ашиглах-Шилжүүлэх (BOT) хэлбэрээр, нийгмийн дэд бүтцийн салбарт 38 хувь нь Барих-Ашиглах-Шилжүүлэх (BOT), 28 хувь нь Шинэчлэн сайжруулах-Ашиглах-Шилжүүлэх (ROT) хэлбэрээр хэрэгжсэн (хүснэгт 3). Харин харилцаа, холбооны салбарт хэрэгжсэн нийт 861 төслийн дийлэнх хувь нь хувийн

Дэд бүтцийн салбарт төр хувийн хэвшлийн түнлэлийг (PPP) хэрэгжүүлэх нь

хэвшлийн бусад оролцоогоор (Merchant) хэрэгжсэн байна.

Хүснэгт 3. 1990-2014 оны Дэлхийн хөгжиж буй орнуудад хэрэгжсэн дэд бүтцийн төслийн хэлбэр

№	Үзүүлэлт	Эрчим хүч		Тээвэрлэлт		Харилцаа, холбоо		Нийгмийн дэд бүтэц	
1	Барих-Ашиглах-Шилжүүлэх (BOT)	926	30%	491	30%	9	1%	336	38%
2	Барих-Өмчлөх-Ашиглах (BOO)	1,205	39%	16	1%	95	11%	26	3%
3	Барих-Шинэчлэн сайжруулах-Ашиглах-Шилжүүлэх (BROT)	124	4%	606	37%	8	1%	159	18%
4	Шинэчлэн сайжруулах-Ашиглах-Шилжүүлэх (ROT)	93	3%	295	18%	2	0,2%	204	23%
5	Бусад төрөл	740	24%	229	14%	747	86,8%	160	18%
	Нийт	3,088	100%	1,637	100%	861	100%	885	100%

Эх сурвалж: Дэлхийн банк. www.worldbank.org

Монгол улсын “Концессийн тухай” хуульд төр хувийн хэвшлийн хамтын ажиллагааны Барих-Шилжүүлэх (Build-Transfer), Барих-Түрээслэх-Шилжүүлэх (Build-Lease-Transfer), Барих-Ашиглах-Шилжүүлэх (Build-Operate-Transfer), Барих-Өмчлөх-Ашиглах-Шилжүүлэх (Build-Own-Operate-Transfer), Барих-Өмчлөх-Ашиглах (Build-Own-Operate), Зураг төсөл боловсруулах-Барих-Санхүүжүүлэх-Ашиглах (DBFO), Шинэчлэн сайжруулах-Ашиглах-Шилжүүлэх (ROT) хэлбэрүүд байж болохыг заасан. Манай улсад 1990-2014 онд нийт 164.0 сая ам.долларын 5 төсөл хэрэгжсэн бөгөөд үүнээс 2012 онд эрчим хүчний салбарт 120.0 сая ам.долларын төслийг Барих-

Өмчлөх-Ашиглах (BOT) төрлөөр хэрэгжүүлсэн. Монгол Улсын Засгийн Газрын тогтоолоор батлагдсан ТХХТ-ээр хэрэгжих 132 зүйлээс 101 зүйл буюу 77 хувь нь Барих-Шилжүүлэх (BT) хэлбэрээр хэрэгжихээр⁴ зааснаас үзэхэд төр хувийн хэвшлийн түншлэлийн энэ хэлбэр голлож байна (хүснэгт 4). Үүнээс эрчим хүчний салбарт тус бүр 31 хувийг BOT, BOO, BT хэлбэрээр, тээвэрлэлтийн салбарт 50 хувийг BT хэлбэрээр, нийгмийн дэд бүтэц, түүний дотор боловсролын салбарт хэрэгжих зүйлийн 91 хувийг BT хэлбэрээр хэрэгжүүлэхээр болсон байна.

Хүснэгт 4. Монгол улсад ТХХТ төсөл хэрэгжих салбар, түншлэлийн хэлбэр

№	Үзүүлэлт	Эрчим хүч		Тээвэрлэлт		Нийгмийн дэд бүтэц	
1	Барих-Ашиглах-Шилжүүлэх (BOT)	4	31%	5	18%		
2	Барих-Өмчлөх-Ашиглах (BOO)	4	31%	6	21%	7	7,9%
3	Барих-Шилжүүлэх (BT)	4	31%	14	50%	83	91%
4	Бусад төрөл	1	7%	3	11%	1	1,1%
	Нийт	13	100%	28	100%	91	100%

Эх сурвалж: www.legalinfo.mn

Төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагаанд хөгжиж буй орнуудад нийтлэг хэрэглэгддэг BOT болон BOO хэлбэр болон манай орны хуулиар зөвшөөрсөн нийтлэг хэрэглэгдэж байгаа BT хэлбэрийн агуулга, онцлог, эрсдлийн байдлыг харьцуулан хүснэгт 5-д үзүүлэв.

⁴ Монгол Улсын Засгийн Газрын тогтоол №317. Төрийн өмчийн концессийн зүйлийн жагсаалт батлах тухай.2013. www.legalinfo.mn

Хүснэгт 5. ТХХТ-ийн BT, BOT болон BOO хэлбэрийн харьцуулалт

Үзүүлэлт		Барих-Шилжүүлэх (BT)	Барих-Ашиглах-Шилжүүлэх (BOT)	Барих-Өмчлөх-Ашиглах (BOO)
Санхүүжилтийн эх үүсвэр		Төр болон хувийн хэвшил	Төр болон хувийн хэвшил	Хувийн хэвшил
Төрийн баталгаа		Зөвхөн бүтээн босголын үед	Зөвхөн концессийн хугацаанд	Байхгүй
Эрсдэл	Бүтээн босголтын	Хувийн хэвшил	Хувийн хэвшил	Хувийн хэвшил
	Ашиглалтын	Төр	Хувийн хэвшил	Хувийн хэвшил
	Концессийн хугацааны дараа	Төр	Төр	Хувийн хэвшил
Хөрөнгийн эзэмшил		Төр	Төр	Хувийн хэвшил

Эндээс үзэхэд BT болон BOT хэлбэрээр тухайн төслийг хэрэгжүүлэхэд төр илүү их эрсдэлийг өөртөө төвлөрүүлж, тодорхой хэмжээний санхүүжилт болон баталгаа гаргаж байгаа боловч тухайн хөрөнгийн эзэмшил төрд үлдэж байгаа нь BOO хэлбэртэй харьцуулахад давуу тал болж байна. Харин BOO хэлбэр нь төрөөс тодорхой санхүүжилт болон баталгаа шаардахгүй боловч хөрөнгийн эзэмшил хувийн хэвшилд шилждэг. Дээрх хэлбэрүүд өөрийн гэсэн давуу болон сул талуудтай байгаа нь төр тухайн хэрэгжүүлэх төслийн онцлогоос хамааруулан хувийн хэвшилтэй хамтран ажиллах хэлбэрээ оновчтой сонгох шаардлагатайг илтгэж байна.

Дүгнэлт, санал:

- Уул уурхай, олборлолтын салбарт түшиглэсэн эдийн засагтай манай улсын хувьд нэн тэргүүнд уул уурхай дагасан дэд бүтцийг яаралтай бий болгох шаардлага зүй ёсоор тавигдаж байна. Судалгаанаас үзэхэд манай улсад ирэх жилүүдэд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн дэд бүтцийн төслүүдийг дан ганц улсын төсвийн хөрөнгөөр санхүүжүүлэх боломжгүй тул дэлхийн бусад орнуудад түгээмэл ашиглагдаж, үр дүнгээ өгч байгаа "Public-Private-Partnership" буюу "Төр хувийн хэвшлийн түншлэл"-ийн загварыг ашиглах шаардлагатай гэж үзлээ.
- Төсөл хэрэгжүүлэх салбарийн онцлог, хувийн өмчийн компаниудын боломж, эдийн засгийн чадавхи зэргийг харгалзан үзэж төр хувийн хэвшлийн хамтын ажиллагааны хэлбэрийг оновчтой сонгох нь зүйтэй. Тухайлбал эрчим хүчний салбарт

Барих-Өмчлөх-Ашиглах (BOO), тээврийн салбарт Барих-Шинэчлэн сайжруулах-Ашиглах-Шилжүүлэх (BROT), эсвэл Барих-Ашиглах-Шилжүүлэх (BOT) хэлбэрийг, харилцаа холбооны салбарт Арилжаалах гэрээ буюу Merchant, нийгмийн дэд бүтцийн салбарт Барих-Ашиглах-Шилжүүлэх (BOT) эсвэл Шинэчлэн сайжруулах-Ашиглах-Шилжүүлэх (ROT) хэлбэрүүдийг ашиглах боломжтой гэж үзэж байна.

Ашигласан эх сурвалж:

- Концессийн тухай, Монгол улсын хууль. www.legalinfo.mn
- Монгол Улсын Засгийн Газрын тогтоол №317, Төрийн өмчийн концессийн зүйлийн жагсаалт батлах тухай, 2013. www.legalinfo.mn
- Ernst and Young Global, Business risks facing mining and metals, 2009-2014.
- John D. Finnerty, Project Financing: Asset-Based Financial Engineering, 2006.
- Damdindorj.N, Reaserch on Theoretical Basis of Project Finance and Its implementation in Mongolian Mining Project. 2012
- "ADBI" working paper series, No. 248, Estimating demand for infrastructure in energy, transport, telecommunication, water and sanitation in Asia and the Pacific: 2010-2020, 2010
- EURASIA Capital, Infrastructure in Mongolia: Challenges and Opportunities, 2009. http://www.associm.com/newsletters/pdf/INFRASTRUCTURE_final.pdf
- PPIAF, PPPs: An Introduction, 2009.
- http://www.ppiaf.org/sites/ppiaf.org/files/documents/PPIAF_Intro_to_PPPs.pdf
- World Bank, Public-Private-Partnerships Reference Guide, Version 2.0, 2014.www.worldbank.org